



► Зохистой хөдөлмөр ба худалдаа (T4DW) төслийн II үе шат Монгол Улс

© ILO 2024

► Товч танилцуулга



Түншлэгч талууд:

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо, Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбоо, болон Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим



Санхүүжилт:

Европын Холбоо



Төсөл хэрэгжих хугацаа:

2024 оны 1-р сараас 2027 оны 12-р сар



Зорилтот бүлэг:

Төрийн байгууллагууд, нийгмийн түншүүд, хөдөлмөр эрхэлж буй хүн ам, хүүхэд залуучууд, эмэгтэйчүүд, хувийн хэвшил, болон экспортын баримжаатай бизнес эрхлэгчид.



Төсөл хэрэгжих улс:

Бангладеш, Кабо Верде, Кот-д'Ивуар, Гана, Мадагаскар, Монгол, Мозамбик, Мьянмар, Пакистан, Филиппин, Вьетнам зэрэг улсууд, мөн Эквадор, Гватемал, Гондурас, Кени, Молдав, Перу, Тажикистан зэрэг улсуудад тодорхой үйл ажиллагааны хүрээнд хэрэгжсэн.

► Үндэслэл

Монгол Улс Олон улсын хөдөлмөрийн байгууллагын (ОУХБ) 1981 оны (155 тоот) 10 суурь конвенцын 9-г нь баталсан. T4DW төсөл нь зохистой хөдөлмөрийг дэмжихийн сацуу Монгол Улсын Европын Холбооны Ерөнхий хөнгөлөлтийн хөтөлбөрт (GSP+) хамрагдах эрхийг хангах зорилготой юм. Ингэхдээ баталсан конвенцуудыг ОУХБ-ын хяналтын байгууллагад тайлагнахад засгийн газар болон нийгмийн түншүүдэд дэмжлэг үзүүлнэ. Мөн төслийн хүрээнд ОУХБ-ын үлдсэн суурь конвенц болох Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг дэмжих тогтолцооны 187 дугаар (2006) конвенцыг түгээн дэлгэрүүлж батлах зорилгоор гурван талт хэлэлцээрийг зохион байгуулж дэмжинэ.


► Төслийн зорилго

Энэхүү төсөл нь хөдөлмөрийн харилцаа болон хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах замаар ОУХБ-ын суурь конвенцуудын Монгол Улс дахь хэрэгжилт, тайлагналыг сайжруулах зорилготой юм.

► Үндсэн үйл ажиллагаа

Монгол Улсад T4DW төсөл нь дараах чиглэлээр үйл ажиллагаа хэрэгжүүлнэ:

- ОУХБ-аас баталсан суурь конвенцуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- Үндэсний эрх зүйн тогтолцоог ОУХБ-ын суурь конвенцод нийцүүлэх сайжруулахын тулд Монгол Улсын эрх зүйн шинэчлэлийг дэмжих
- Олон улсын хөдөлмөрийн стандарт, хөдөлмөрийн хүрээний суурь зарчим, эрхийн талаар холбогдох байгууллагууд болон нийгмийн түншүүдийн чадавхыг бэхжүүлэх
- Тухайн улсын тайлагнах үүргээ биелүүлэх чадавхыг бэхжүүлэх



► Үр дүн | 2021 - 2024

- Юун түрүүнд ОУХБ-ын T4DW төсөл нь тайлагнах чадавхыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ үндэсний эрх зүйн тогтолцоог ОУХБ-аас баталсан конвенцод нийцүүлэхийн тулд засгийн газартай хамтран ажилласан. Үүнтэй холбоотой ОУХБ-ын Конвенц, зөвлөмжийн хэрэгжилтийг хянах шинжээчдийн хорооноос (CEACR) санал хүсэлтийг шийдвэрлэхийн тулд Олон улсын хөдөлмөрийн стандартыг нэвтрүүлэх үндэсний гурван талт дэд хороонд төслийн зүгээс техникийн дэмжлэг үзүүлсэн. Энэхүү хамтын ажиллагаа нь ОУХБ-д дэлгэрэнгүй тайлан бэлтгэхэд дэмжлэг болсон.
- Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль 2021 онд шинэчлэгдсэний дараа T4DW төсөл нь шинэ хуулийн үр дүнтэй нэвтрүүлэхэд шаардлагатай зохицуулалтуудыг боловсруулахад дэмжлэг үзүүлсэн. Мэдээлэл харилцааны шинэлэг стратегиудыг ашиглан Хөдөлмөрийн тухай хуулийн гол зүйл заалтуудын талаарх мэдээллийг түгээх зорилгоор 18 богино хэмжээний бичлэг, 10 комикс бэлтгэсэн байна. Энэхүү санаачилгыг НҮБ-ын Залуучуудын зөвлөх хороотой хамтран нийгмийн сүлжээг ашиглан зорилтот компанит ажлыг зохион байгуулснаар олон нийтэд таниулан сурталчлах, тэдний оролцоог нэмэгдүүлсэн. Эдгээр сурталчилгааны материалуудыг засгийн газар, нийгмийн түншүүд, ТББ-ууд үйл ажиллагаанд одоог хүртэл өргөнөөр ашиглаж байна.
- Цаашлаад, уг төсөл нь хуулийн мэргэжилтнүүдийн олон улсын хөдөлмөрийн стандартыг практикт нэвтрүүлэх мэдлэг, ур чадварыг чадавхжуулсан. Эдгээр мэргэжилтнүүдийг ОУХБ-ын Олон улсын сургалтын төв (ITC/IO) болон Монголын хуульчдын холбоотой хамтран зохион байгуулсан ахисан түвшний сургалтад хамруулсан болно.
- Төслийн зүгээс хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг таниулан сурталчлахын зэрэгцээ ажлын байран дахь дарамт, хүчирхийлэл, хүүхдийн хөдөлмөр эсрэг чиглэсэн үйл ажиллагаануудыг идэвхтэйгээр хэрэгжүүлсэн. ОУХБ-аас ажил олгогчдод зориулан гаргасан ажлын байран дахь дарамт, хүчирхийллийн талаарх практик гарын авлагыг тарааж сургалтын модулиуд болон бодлогын түрвшний зөвлөмжүүдийг боловсруулах ажлыг удирдан чиглүүлснээрээ онцлог юм.
- Төслийн зорилгын хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай стратегийн хувьд уялдаа холбоотой ажиллаж, Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг дэлхийн өдрөөр үндэсний бодлогын хэлэлцүүлэг, хүүхдийн хөдөлмөрийн цогц сургалтыг зохион байгуулсан. Түүнчлэн, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст Хүүхдийн хөдөлмөрийн чанарын судалгааг хийхэд тус төслөөс дэмжлэг үзүүлсэн. Тус судалгаагаар насанд хүрээгүй хүмүүст хориглосон ажлын байрны жагсаалтад өөрчлөлт оруулах, хүүхдийн хөдөлмөрийн хөнгөн нөхцөлийг тодорхойлох зэрэг бодлогын нэн чухал шинэчлэлүүдийг боловсруулсан болно.

► Холбоо барих хаяг:

Мягмарын Жавзандулам
Төслийн зохицуулагч
И-мэйл хаяг: myagmar@ilo.org
Нэгдсэн үндэстний
байгууллагын гудамж 12,
Сүхбаатар дүүрэг, 6 дугаар
хороо Улаанбаатар хот, 14201,
Монгол Улс

► T4DW төслийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл:



 www.ilo.org/mongolia

 Олон улсын хөдөлмөрийн байгууллага -
International Labour Organization

 @ilo_mongolia